



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/241

Булган сум

### Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД81-16-20, 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 57/2022 дугаартай гэрээний 3 дахь заалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Баяннуур сумын 2013 онд хийгдсэн Соёлын төвийн засварын зураг төсвийг өнөөгийн инфляцийн түвшинд нийцүүлэн шинэчлэх ажлыг 15,400,000 (арван таван сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр “Өлзий иш” ХХК-тай шууд гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Өлзий иш” ХХК (А.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.

2. Булган аймгийн Баяннуур сумын 2013 онд хийгдсэн Соёлын төвийн засварын зураг төсвийг өнөөгийн инфляцийн түвшинд нийцүүлэн шинэчлэх ажлын явцад хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Булган аймгийн Баяннуур сумын 2013 онд хийгдсэн Соёлын төвийн засварын зураг төсвийг өнөөгийн инфляцийн түвшинд нийцүүлэн шинэчлэх ажлыг гэрээнд заагдсан санхүүжилтийг аймгийн ИТХ-ын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын 1.4-д тусгагдсан төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

11 6323010220